



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны 7 дугаар сар


Улаанбаатар
2019



1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өсч 20.3 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 9.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 4.3 нэгж хувийг төгрөгийн харилцах, 2.3 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн байна.

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 17.9%-иар нэмэгдсэн байна.




Нийт хадгаламжийн хэмжээ 13.8 их наяд төгрөгт хүрснээс 84.1 хувь буюу 11.6 их наяд төгрөг нь иргэдийн, 15.6 хувь буюу 2.2 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 20.9 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 20.7 хувийг, байгууллагын хадгаламжийн 21.7 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 18%-иар өсч 13.9 их наяд ₮-т хүрчээ.




Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 60.5 тэрбум төгрөгөөр өсчээ. Тодруулбал улсын байгууллагын төгрөгийн харилцах, гадаад валютын хадгаламж буурч, гадаад валютын харилцах нэмэгдсэн байна. Мөн хувийн байгууллагын харилцах буурч, хадгаламж нэмэгдсэн байгаа бол иргэд төгрөгийн харилцах буурч, хадгаламж нэмэгдсэн байна.

M2 өмнөх сараас 60.5 тэрбум ₮-өөр өсчээ.



M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.3 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 2 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 18.6 нэгж хувийг ГЦА, -0.7 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна. ГЦА-ын өсөлтөнд Төв банкны гадаад цэвэр актив нэмэгдсэн нь нөлөөлсөн байгаа бол ДЦА буурсан нь Төв банкнаас Засгийн газарт өгөх өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.


M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



2. БАНКУУДЫН ЗЭЭЛ

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 22.2 хувиар өсч 9.3 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 11.9 хувиар өсч 8.7 их наяд төгрөгт тус тус хүрчээ.


Нийт зээлийн үлдэгдэл 18.1 их наяд ₮-т хүрч, жилийн 18.2%-иар өсөв



Нийт зээлийн үлдэгдлийн 13.5 хувь буюу 2.4 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна. Тодруулбал, иргэдийн зээлийн 1.6 хувь, хувийн байгууллагын зээлийн 25.8 хувь нь гадаад валютаар олгогдсон байна.

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 274.2 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 134.1 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Шинээр олгосон зээлийн 13.6 хувь буюу 239.6 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

Тайлант сард 1,768 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1,646 тэрбум ₮ эргэн төлөгдлөө



Өмнөх сартай харьцуулахад нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өөрчлөгдөөгүй, харин хугацаа хэтэрсэн зээл 0.7 нэгж хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн 83.5 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 73.4 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.


Чанаргүй зээл нь нийт зээлийн 10.6%, хугацаа хэтэрсэн зээл 4.8% байна



Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,926.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 18.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 20.2 хувь нь гадаад валютаар олгогджээ.


Чанаргүй зээлийн 23.8 хувийг уул уурхай, 21.1 хувийг боловсруулах, 11.2 хувийг барилга, 8.4 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл эзэлж байна.

Чанаргүй зээл, салбараар. Чанаргүй зээлийн 83.5 хувь нь хувийн байгууллагын, 16.2 хувь нь иргэдийн зээл байна




Тайлант сард хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 179.4 тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнд, барилгын салбарын зээл 86.1 тэрбум, худалдааны салбарын зээл 51.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах, уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв.



Тайлант сард хувийн байгууллагад 971.1 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 21.8 хувь буюу 211.8 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Худалдаа, уул уурхай, боловсруулах, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.

Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц




Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 7.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнээс цалин, тэтгэврийн зээл 39.5 тэрбум, автомашины зээл 8.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан. Харин ипотекийн зээл 13.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Иргэдийн зээлийн 37%-ийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар), 34%-ийг цалин, тэтгэврийн зээл бүрдүүлэв.



Тайлант сард иргэдэд 757.5 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 3.7 хувь буюу 27.8 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Иргэдэд шинээр олгосон зээлийн дийлэнх буюу 24.3 хувийг хадгаламж барьцаалсан, 18.4 хувийг цалин, тэтгэврийн, 15.5 хувийг картын зээл тус тус бүрдүүлсэн байна.

Иргэдэд шинээр олгосон зээлийн бүтэц



ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах, барилгын салбарын зээл эзэлж байна.




ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 4,022 тэрбум төгрөгт хүрснээс 32.7 хувийг худалдааны салбарт, 14.7 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 12.8 хувийг барилгын салбарт, 7.9 хувийг үйлчилгээний салбарт тус тус олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 3.6 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 13.5 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


2019 оны 7 дугаар сарын байдлаар 94843 зээлдэгч нийт 4.5 их наяд төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 70461 зээлдэгч 3.3 их наяд төгрөгийн зээл авчээ.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт: 3.7%



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.4 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.0 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 4.6 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Ипотекийн зээлийн 74.4 хувийг хөтөлбөрийн зээл эзэлж байна.




Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 78.0 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 19.3 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 2.7 хувь нь бусад эх үүсвэрээр олгогдсон ба нийт 24808 ипотекийн зээлдэгч байна.

Нийт ипотекийн зээлийн 922.5 тэрбум төгрөг буюу 20.5 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 17.0 хувь буюу 766.3 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.

¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.0 хувийг орон нутагт байршилтай орон сууцанд олгожээ.



Ипотекийн зээлийн 83.0 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.



Тайлант сард 57.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 45.5 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 54.5 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.2 хувь нь хэвийн, 2.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.0 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 58.0 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 40.7 хувийг хөтөлбөрийн зээл, 1.3 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Тайлант сард шинээр 741 зээлдэгчдэд ипотекийн зээл шинээр олгожээ.



Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 15.5 тэрбум төгрөгөөр, чанаргүй зээл 1.4 тэрбум төгрөгөөр тус тус өсөв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурчээ.



4. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2666.00 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.3 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2661.55 төгрөг байв.

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг сулрав.



Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 0.1 хувиар суларч 387.29 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 386.07 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 388.43 төгрөг байлаа.

Төгрөгийн ханш юаний эсрэг сулрав.



5. ХҮҮ


2019 оны 7 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 10.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурав. Гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч 4.8 хувьд хүрэв. Иргэдээс татсан төгрөгийн хадгаламж 11.2 хувь, хувийн байгууллагаас татсан хадгаламж 9.0 хувийн хүүтэй байна.

Шинээр татсан хадгаламжийн хэмжээ, хүү




Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.1¹ хувьтай бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Иргэдэд олгосон зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурч 17.4 хувьд хүрсэн байна. Тайлант сард нийт иргэдэд 731.5 тэрбум төгрөгийн зээл олгосноос дийлэнх нь буюу 72.4 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

Шинээр олгосон нийт зээлийн хэмжээ, хүү




¹ Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

Шинээр татсан хадгаламжийн хүүний тархалт




Шинээр олгосон зээлийн хүүний тархалт




2019 оны 7 дугаар сард нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээрх ЖДХ 11.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 5.0 хувьтай байна. Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 11.5 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 5.0 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 11.5 хувь, гадаад валютын хадгаламжийн 4.7 хувьтай байна.

Мөн тайлант сард нийт төгрөгийн зээлийн үлдэгдлээрх ЖДХ 17.0 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.8 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.9 хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.5 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.7 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.7 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хадгаламжийн хүү, үлдэгдлээр




Зээлийн хүү, үлдэгдлээр




Тухайн сард шинээр олгосон зээл болон тухайн сард шинээр татсан хадгаламжийн хүүний зөрүү 2019 оны 7 дугаар сарын байдлаар 6.8 хувьд хүрэв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан байна.

Зээлийн эргэн төлөгдөж дуусах хугацаагаар нь авч үзвэл нийт зээлийн 42.6 хувийг 24 сараас доош хугацаанд төлөгдөж дуусах зээл, 57.4 хувийг 2 жилээс дээш хугацаанд төлөгдөж дуусах зээл эзэлж байна.

Төгрөгийн зээл, хадгаламжийн хүүний харьцаа



Зээлийн үлдэгдэл, хугацаагаар



6. ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 9.0 хувьд хүрч өмнөх сараас өссөн байна. Үүнээс 6.2 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 2.8 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хувцас, орон сууцны түрээс болон урсгал засвартай холбоотой бараа, үйлчилгээний үнийн өсөлт, хүнсний барааны бүлгийн үнэд махны үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Харин хүнсний ногооны үнэ буурсан байна.

УБ хотын хэмжээнд сарын инфляци 0.2 хувьтай гарснаас -0.2 нэгж хувийг хүнсний бараа, 0.4 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Хүнснээс бусад барааны үнэ өсөхөд голлон орон сууцны түрээс болон урсгал засвартай холбоотой бараа, үйлчилгээний үнийн өсөлт нөлөөлжээ. Харин хүнсний барааны үнэ буурахад сүү болон хонь, ямааны махны үнийн бууралт нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 9.0 хувь



УБ хотын сарын инфляци 0.2 хувь



6. ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 9.0 хувьд хүрч өмнөх сараас өссөн байна. Үүнээс 6.2 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 2.8 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хувцас, орон сууцны түрээс болон урсгал засвартай холбоотой бараа, үйлчилгээний үнийн өсөлт, хүнсний барааны бүлгийн үнэд махны үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Харин хүнсний ногооны үнэ буурсан байна.

УБ хотын хэмжээнд сарын инфляци 0.2 хувьтай гарснаас -0.2 нэгж хувийг хүнсний бараа, 0.4 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Хүнснээс бусад барааны үнэ өсөхөд голлон орон сууцны түрээс болон урсгал засвартай холбоотой бараа, үйлчилгээний үнийн өсөлт нөлөөлжээ. Харин хүнсний барааны үнэ буурахад сүү болон хонь, ямааны махны үнийн бууралт нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 9.0 хувь




УБ хотын сарын инфляци 0.2 хувь




ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ

Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /сектороор/




Зураг 2.3. Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа /зээлийн төрлөөр/



Зураг 2.4. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлтийн задаргаа /салбараар/




Зураг 2.5. Тайлант сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл



Зураг 2.6. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.7. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. Чанаргүй зээлийн дүн



Зураг 2.9. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.10. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.11. Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц




Зураг 2.12. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.13. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/




Зураг 2.14. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь




3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Тухайн сард олгосон ипотекийн зээл, санхүүжилтийн эх үүсвэрээр




Зураг 3.3. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.4. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар



Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он




Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт




Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл




4. ХҮҮ

Зураг 4.1. Хугацаагүй хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Зураг 4.2. Хугацаатай хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Зураг 4.3. Нийт зээлийн үлдэгдлийн хүүний тархалт

их наяд ₮

